



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН УЛС ОРНЫ САНААЧИЛГА - МОНГОЛ УЛС

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН УЛС ОРНЫ САНААЧИЛГА - МОНГОЛ УЛС

“Тогтвортой хөгжлийн боловсрол 2030: Монгол Улсын санаачилга”-ыг БШУЯ-ны мэргэжилтнүүд, БСҮХ-гийн эрдэм шинжилгээний ажилтнууд болон ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комиссын дэмжлэгтэйгээр боловсруулсан. Уг санаачилгын бичгийн төслийг бусад яамд, агентлаг болон орон нутгийн төлөөлөлд танилцуулах, хэлэлцүүлэх, санал авах ажлыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулав.

Энэхүү санаачилгад ЮНЕСКО-гоос удирдамж болгосон Замын зураглалыг баримтлан бодлогыг уялдуулах, суралцахуйн орчинг хувирган өөрчлөх, сурган хүмүүжүүлэгчдийн чадавхыг бий болгох, залуучуудад боломж, эрх мэдэл олгох, орон нутгийн түвшний үйлийг хурдасгах гэсэн үйлийн тэргүүлэх таван чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагааг ялган тодорхойлсон болно.

ННА 74
ДАА 370
Т-441

Эмхэтгэсэн:

У.Түяа Ph.D (Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч)

Х.Энхжаргал (Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн ЭША)

Хянан тохиолдуулсан:

М.Итгэл Ph.D (Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал)

Формат: 210x297мм

Хэвлэлийн хуудас: 1.5х.х

Хэвлэсэн тоо: 400ш

“Содпресс” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-9919-9714-6-5

Улаанбаатар хот, 2022 он.

ӨМНӨХ ҮГ

Дотоод, гадаад олон хүчин зүйлсийн нөлөөгөөр хүн төрөлхтөний өмнө тулгарч буй сорилтуудын улмаас дэлхий ертөнц улам бүр хувьсан өөрчлөгдөж байна. Энэ нь хүний хөгжлийн үндэс суурь болсон боловсролд нөлөөлж байгааг олон улс орон хүлээн зөвшөөрч, сүүлийн жилүүдэд өргөн оролцоотойгоор хэлэлцэж байгаа билээ.

БСҮХ-ийн эрдмийн хамт олон 2021, 2022 онд салбарын болон үндэсний хэмжээнд зохион байгуулсан сургалт, үүлзалт, хэлэлцүүлгийн үр дүнд боловсруулсан “ТХБ 2030 Монгол Улсын санаачилга” (2021)-ын төслийг хүргэж байна. Олон талын санал, санаачилгыг тусгасан энэхүү баримт бичиг нь цаашид судлаачид, бодлого боловсруулагчид төдийгүй боловсролын төлөө сэтгэлээ чилээн буй хэн бүхэнд олон нийтийн санаа бодлыг танин мэдэхэд ач холбогдолтой юм.

“Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) 2030: Монгол Улсын санаачилга”-д ТХЗ-д хүрэхийн тулд Монгол Улсын хэрэгжүүлэх үйл ажиллагаа (activity)-г багтаасан бөгөөд Монгол Улсын үрт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө, үндэсний болон олон улсын судалгаагаар тодорхойлсон түршлага, сургамжийг үндэслэсэн болно. Мөн нийгмийн хамгааллын, хөдөлмөрийн, хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын болон орон нутгийн төлөөллийн саналыг цуглуулж, тусгасан.

Дээрх санаачилгыг боловсруулах, үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулах үйл ажиллагаа нь боловсролын талаар хамгийн өргөн, олон оролцогчид хамтаараа ярилцаж, хэлэлцсэн онцлогтой бөгөөд хэлэлцүүлгийн оролцогчид “боловсрол бол бүх нийтийн сайн сайхан”-ны үндэс, “боловсрол бүх нийтийн зорилго” болохыг чухалчилсныг тэмдэглэж байна.

Бидний зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон бүх хүүхэд, залуучууд, байгууллагын төлөөлөл болон манлайлал үзүүлсэн БШУЯ, хамтран ажиллаж, дэмжсэн НҮБ-ын байгууллагуудад Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн талархлыг уламжилж байна.

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА ХИЧЭЭЦГЭЭЕ.

БСҮХ-ийн ЗАХИРАЛ



М.ИТГЭЛ Ph.D

ТОВЧИЛСОН ҮГ

УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
МУЗГ	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЗГХЭГ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
БШУЯ	БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭМЯ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
БОАЖЯ	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ХНХЯ	ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ХХААЯ	ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ
СЯ	САНГИЙН ЯАМ
БХТЯ	БАРИЛГА ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЯАМ
НХХЯ	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА
ШХА	ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ
БСҮХ	БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
БХ	БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН
БҮТ	БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ
НТБҮТ	НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
БМТТ	БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ТӨВ
БМДИ	БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ
МУБИС	МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
БОМСТ	БАЙГАЛЬ ОРЧИН МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН ТӨВ
МҮОНРТ	МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗ
МХЕГ	МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЗЦГ	ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР
ИНБ	ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА
ОНХС	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН
ТЗЗҮБ	ТЕХНИКИЙН ЗӨВЛӨН ЗОХИЦУУЛАХ БАГ
ТХ	ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ
ТХБ	ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ
ТХЗ	ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ
ҮК	ҮНДЭСНИЙ КОМИСС
БДБ	БАГА ДУНД БОЛОВСРОЛ
СӨБ	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
ДБСБ	ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА
НТС	НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙ
СБААХ	СУРГУУЛЬ БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ АРГА ХАНДЛАГА
ББААХ	БАЙГУУЛЛАГА БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ АРГА ХАНДЛАГА
ҮТЧ	ҮЙЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН УЛС ОРНЫ САНААЧИЛГА – МОНГОЛ УЛС

Танилцуулга

1. Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) 2030: Монгол Улсын санаачилгад 2020-2030 онд тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ)-д хүрэхийн тулд Монгол Улсын хэрэгжүүлэх үйл ажиллагаа (activity)-г багтаасан. Энэхүү санаачилгыг боловсруулахдаа Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө, үндэсний болон олон улсын судалгааны үр дүнд тодорхойлсон холбогдох туршлага, сургамжийг үндэслэсэн болно.
2. Энэхүү санаачилгад ЮНЕСКО-гоос удирдамж болгосон Замын зураглалыг баримтлан бодлогыг уялдуулах, суралцахуйн орчинг хувирган өөрчлөх, сурган хүмүүжүүлэгчдийн чадавхыг бий болгох, залуучуудад боломж, эрх мэдэл олгох, орон нутгийн түвшний үйлийг хурдасгах гэсэн үйлийн тэргүүлэх таван чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагааг ялган тодорхойлсон.
3. Санаачилгыг Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-ны манлайлал дор түүний харьяа Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд болон БШУЯ-ны мэргэжилтнүүд ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс (ҮК)-ын дэмжлэгтэйгээр томилогдсон ажлын хэсэг боловсруулсан. Уг ажлын хэсгийн боловсруулсан санаачилгын эхний төслийг үндэсний хэмжээнд нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, хүнс, хөдөө аж ахуйн ... зэрэг төрийн захиргааны байгууллагын болон орон нутгийн төлөөлөлд танилцуулан хэлэлцүүлж, тэдний саналыг цуглуулж тусгасан болно.

1. Суурь мэдээлэл

- 1.1. Улс орны тогтвортой байдлыг хангахад тулгарч буй гол сорилтууд болон боломжууд

Боломж

- Монгол Улс ТХБ-ыг үзэл баримтлал болон агуулгын хувьд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогодоо тусгасан байна.
- Алсын хараа-2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Засгийн газраас 2020-2030 онд хэрэгжүүлэх хөгжлийн 7 зорилтот хөтөлбөрийг боловсруулж байгаа бөгөөд үүнд “Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “Байгаль орчны зорилтот хөтөлбөр” багтаж байна. Энэ нь салбар бүрийн тус тусдаа, салангид байсан урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрийг үндэсний хэмжээний урт хугацааны хөгжлийн бодлогодоо нийцүүлэн нэгтгэх, салбарууд хамтран ажиллах, хамтын үүрэг хариуцлага хүлээх давуу талтай юм. Зорилтод хөтөлбөрүүдийг боловсруулахдаа салбар бүрийн оролцоог хангаж, тус бүрийг тодорхой нэг яамны манлайлал дор хэд хэдэн яамд хамтран ажиллаж байна. Тухайлбал, “Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулахаар БШУЯ, Эрүүл мэндийн яам, Соёлын яамны төлөөлөл бүхий салбар дундын ажлын хэсгийг байгуулсан

байна. Мөн уг зорилтот хөтөлбөрүүдэд тогтвортой хөгжил, түүний дотор ТХБ-ын зорилтуудыг тусгах матрицыг боловсруулсан байна.

- БШУЯ-наас шинэчилэн найруулж, УИХ-д өргөн барьсан Боловсролын тухай багц хуулийн төслүүд болон хуулийн үзэл баримтлалаас харахад “ТХЗ 4-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалт хангалттай түвшинд тусгагдсан” гэж ТХЗ 4-ийн ахиц дэвшлийн тойм үнэлгээний төсөлд дүгнэсэн байна.
- Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2021-2030)-г 2020 онд БШУЯ-аас баталсан. Энэ төлөвлөгөөнд насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх, тогтвортой хөгжлийн зорилго 4-ыг хангахад чиглэсэн олон үйл ажиллагаанууд төлөвлөгдсөн.
- Сурагчдын хоцрогдлыг нөхөн арилгах 3 жилийн төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна.

Сорилт, бэрхшээл:

- ТХБ 2030-ын үйлийн тэргүүлэх чиглэл (ҮТЧ)-ийн хүрээнд ҮТЧ 1-ээс бусад чиглэлийн хувьд өнөөгийн байдал сул үнэлэгдсэн. Ялангуяа ҮТЧ 3-ын хувьд сургалтын байгууллагуудын материаллаг орчин ба үйл ажиллагаанд тогтвортой байдлын зарчмууд биеллээ олдог эсэх, ҮТЧ 4-ийн хувьд 4 үзүүлэлтээс 3 нь, ҮТЧ 5-ын ТХБ-ыг орон нутгийн хэмжээнд урамшуулах үндэсний түвшний бодлогын дэмжлэг байдаг эсэх гэх зэрэг үзүүлэлтүүд 1 гэсэн үнэлгээтэй байгаа нь Тогтвортой хөгжил (ТХ)-ийн төлөө байгууллага бүхлээрээ ажиллах арга хандлага төлөвшөөгүй, ТХ-д залуусын оруулах хувь нэмэр бага, тэдний оролцоог хангах механизм бүрдээгүй, орон нутгийн түвшинд ТХБ-ыг түгээн дэлгэрүүлэх санаачилга сул, үндэсний дэмжлэг хангалтгүй байдгийг илтгэж байна.
- Салбар хоорондын хамтын ажиллагаа сул байна. Боловсролын болон тогтвортой хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, мэргэжлийн агентлагуудын хүн бүрийн насан туршин суралцахуй (НТС)-н тогтолцоог бүрдүүлэхэд төвлөрсөн хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах шаардлагатай байна.
- Сурган хүмүүжүүлэгчдийн ТХ, ТХБ-ын мэдлэг, ойлголт хангалтгүй, тэдгээрийг эзэмшүүлэх арга барил, чадавх зохих түвшинд бүрдээгүйгээс суралцагчид буюу өөрчлөлтийг бий болгогчдод хэрэгтэй мэдлэг, үр чадвар, хандлагыг бүрэн төлөвшүүлж чадахгүй байна гэж үзэх үндэс байна. Нөгөө талаар сурган хүмүүжүүлэгчид болон суралцагчдын ТХБ-ыг илрүүлэх, хэмжих шалгуур үзүүлэлт, мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй байна.
- Залуучуудын оролцоо, тэдэнд эрх мэдэл олгоход чиглэсэн үйл ажиллагаа нь улс төрийн нам, бүлэглэлээс ихээхэн хамааралтай байдаг. Ингэснээр залуусын оролцоог хангах, эрх мэдэл олгоход чиглэсэн үйл ажиллагаа улс төрийн ашиг сонирхолтой үйл ажиллагаа мэтээр ойлгогдох эрсдэлтэй.
- КОВИД 19 нь зарим нэгэн боломжийг нээснээс гадна боловсролын салбарт хүндхэн сорилт бэрхшээлийг бий болгосон. Монгол Улс харьцангуй урт хугацаанд

танхимын сургалтыг хаасан улсын нэг¹ байсан бөгөөд энэ үед:

- сурагчдын хувьд суралцахуйн алдагдал (хоцрогдол) нэмэгдсэн,
- багш нарын цахим бичиг үсгийн түвшин харьцангуй доогуур байсан зэргийг улс орны санаачилгын түвшинд авч үзэх шаардлагатай.

1.2. ТХБ-2030-ын тэргүүлэх чиглэлтэй холбоотой Монгол Улсын ТХБ-ын өнөөгийн байдал

ТХБ-2030-ын үйлийн тэргүүлэх чиглэл	Тэмдэглэл бага 1, дундаж 2, 3, их 4 аль нэгийг V сонгоно уу.	ТХБ-ын гол хөгжүүлэлтүүд	Шаардлагатай бол холбогдох лавлагаа (холбогдох URL хаяг)
Үйлийн тэргүүлэх чиглэл 1: Бодлогыг нарийвчлан уялдуулах	1 2 3 4 V	ТХБ-ын үндэсний бодлого байдаг.	https://legalinfo.mn - Алсын хараа-2050: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020-2050). Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) - Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2030) - Боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030) - Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого 2014-2024 (хүчингүй болсон) - ТХБ-үндэсний хөтөлбөр (2018-2022)
	1 2 3 4 V	ТХБ нь байгаль орчин, тогтвортой хөгжил, ТХЗ-уудын талаар үндэсний бодлогод тусгагдсан болно.	
	1 2 V 3 4	ТХБ нь боловсролын байгууллагуудын боловсролын чанарын баталгааны шалгуурт тусгагдсан болно.	https://www.meds.gov.mn/post/64542 - БСШУ-ны сайдын тушаал № 419, 2019 оны А/491, 803 (Сургууль, СӨБ-ын байгууллагыг үнэлэх) http://inspection.gov.mn/new/?page_id=23 - МХЕГ-ын сургууль цэцэрлэг, их дээд сургуулийн хяналтын хуудсууд (Код: 6.1-6.4, 6.9)

¹ Э.Эрдэнэчимэг, Боловсрол ба КОВИД-19, Төрийн байгуулал судлал. №02, 2020

Үйлийн тэргүүлэх чиглэл 2: Сургалтын орчныг хувирган өөрчлөх	1 2 ✓ 3 4	ТХБ нь сургалтын хөтөлбөрийн үйлийн хүрээнд тусгагдсан болно.	http://www.mier.mn/archives/category/esd - ТХЗ-ын төлөөх боловсролыг суралцахуйд интеграцчилах бодлого, арга хандлага: Багц ном, БХ, ШХА, 2021 https://www.mier.mn/archives/4479 - ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт ТХБ тусгагдсан байдлын шинжилгээ. ШХА, БХ, 2019, "ТХБ – II төсөл"
	1 2 ✓ 3 4	ТХБ-ын хүрээнд ББААХ сургалтын байгууллагуудад тэр дундаа ЮНЕСКО-ийн Холбоот сургуулиудад хэрэгждэг.	https://www.esdmongolia.com - Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага: Багц гарын авлага. ШХА, БОМСТ, "ТХБ – II төсөл" https://www.Ecoschools.mn - Эко сургууль хөтөлбөрүүд
	1 ✓ 2 3 4	Сургалтын байгууллагуудын материаллаг орчны ашиглалт ба ажиллагаанд тогтвортой байдлын зарчмууд биеллээ олдог.	- "ТХБ-II төсөл"-ийн дунд хугацааны мониторинг (2019-2021) хийгдэж байна. 2022 оны эхээр бэлэн болно.
Үйлийн тэргүүлэх чиглэл 3: Сурган хүмүүжүүл-эгчдийн чадавхийг бий болгох	1 2 ✓ 3 4	Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад ТХБ-ын агуулгыг оруулах	- ТХБ-II төслийн суурь судлагааны тайлан https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Orders/Order%202021%20A-190.pdf - Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө (2021-2023) https://www.mier.mn/archives/4623 http://www.itpd.mn/intro - МУБИС-ийн "Жендэрийн мэдрэмжтэй суралцахуй" хичээлийн хөтөлбөр
	1 2 ✓ 3 4	Техникийн болон, мэргэжлийн боловсрол ба сургалтыг ногоон болгоход чиглэсэн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.	- Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2030) - Байгаль орчин, аялал жуулчлалын яам НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийн чиглэлийн их, дээд сургуулиудад "Ногоон эдийн засаг" хичээлийг сургалтын хөтөлбөрт оруулсан.
	1 ✓ 2 3 4	ТХБ-ын үе тэнгийнхэний суралцахуй болон ТХБ-ын сайн туршлагуудыг хүлээн зөвшөөрөх боломжууд байдаг. Багш нарын үнэлгээнд тэдний ТХБ -ын чадавхыг хүлээн зөвшөөрдөг.	https://legalinfo.mn - Багшийн ажлыг үнэлж дүгнэх журам

Үйлийн тэргүүлэх чиглэл 4: Залуучуудад боломж, эрх мэдэл олгох	1 2 3 4	Залуучууд нийгэм дэх тогтвортой байдлын төлөөх хувирган өөрчлөлтөд татагдан оролцож, хоорондоо холбогдон бие биедээ боломж, эрх мэдэл олгох боломжийг өргөжүүлсэн хүртээмжтэй платформтой байдаг.	https://www.Eduexpo.mn - 2021 оны 5 дугаар сард "ТХБ-II" төслөөс зохион байгуулсан "ТХБ-ын төлөөх түншлэл-хамтын санаачилга" нэгдсэн вертуал арга хэмжээний тайлан. БХ, 2021
	1 2 3 4	Тогтвортой байдлын болон боловсролын асуудлаар шийдвэр гаргах байгууллагуудад залуучуудын оролцоог баталгаажуулдаг.	https://www.esdmongolia.com/ - "ТХБ-ын төлөөх хамтын санаачилга, түншлэл" нэгдсэн вертуал арга хэмжээний зарим үр дүн тайлан БХ, 2020
	1 2 3 4	Залуучуудын бүлэг, байгууллага, сүлжээ нь ТХБ-ын үйл хэрэгт оролцдог.	
Үйлийн тэргүүлэх чиглэл 5: Орон нутгийн түвшний үйлийг хурдасгах	1 2 3 4	Засаг захиргааны байгууллагуудын болон орон нутгийн бодлогод ТХБ-ын тухайлбал, насан түршийн суралцахуйн бодлого туссан байдаг.	
	1 2 3 4	ТХБ-ыг орон нутгийн болон улсын хэмжээнд урамшуулах үндэсний түвшний бодлогын дэмжлэг байдаг.	http://www.mier.mn/ - БХ, ЮНЕСКО, Боловсролын бодлогын тойм шинжилгээний тайлан (2019)
	1 2 3 4	Тогтвортой байдлын талаар шийдвэр гаргагчид, нийгмийн бодол санааг манлайлагчид түүнчлэн олон нийтийн чадавхын хөгжил бий.	- БХ, Боловсролын чанар, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн бодлогын судалгаа, 2020 https://www.mn.undp.org - МУЗГ. Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл, 2019

2. Алсын хараа болон зорилтууд

2.1. ТХБ 2030 Монгол Улсын санаачилгын алсын хараа

ТХБ-ыг бодит үйл хэрэг болгохын тулд суралцахуй ба боловсролыг хувирган өөрчлөхөд шаардлагатай тэргүүлэх чиглэл, гол үйл ажиллагаанд сонирхлын бүлгүүд, олон нийтийг хүчин чармайлтыг төвлөрүүлж, Монгол Улсын ТХ-ийн төлөө байгууллага, иргэн бүр хамтарч ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлэн ТХЗ-уудад хүрэхэд хувь нэмэр оруулна.

2.2. Ерөнхий зорилт болон урт, богино хугацааны товлосон зорилтууд

Зорилт:

- Урт хугацаанд хүлээгдэж буй үр дүн (2030 хүртэл):
 - ТХБ-ыг эзэмшиж, тогтвортой амьдрахад нь туслах хүн бүрийн насан туршдаа суралцахуйн үндэсний тогтолцоог бүрдүүлсэн байна.
 - Засгийн газрын Хүний хөгжлийн болон Байгаль орчны зорилтот хөтөлбөрт ТХБ-ыг тусгаж, ТХБ-2030 үйлийн хүрээний хэрэгжилтэд ахиц дэвшил гарсан байна.
 - Сургалтын байгууллагуудад “Сургууль бүхлээрээ ажиллах” арга хандлага нэвтэрсэн байна.
 - Сургалтын байгууллагуудын суралцахуйн орчин ТХ-ийн зарчимд нийцтэй, байгальд ээлтэй, хүртээмжтэй болж, ногоон худалдан авалт, ногоон оффиссын стандартууд хэрэгжиж эхэлсэн байна.
 - Багш бэлтгэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалтад ТХБ-ыг бүрэн тусгасан байна.
 - ТХ-д хүүхэд, залуучуудын оруулах хувь нэмэр, инклюзив оролцоог хангасан нээлттэй, хүртээмжтэй платформыг бий болгож хөгжүүлсэн байна.
 - ТХБ-ын чиглэлээр орон нутгийн түвшинд олон нийт, иргэдэд зориулсан платформууд хөгжиж, тэдний гаргасан санаачилгыг урамшуулах, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх механизмыг бүрдүүлсэн байна.
- Богино хугацаанд хүлээгдэж буй үр дүн (2025 хүртэл):
 - 2024 онд шинэчлэн боловсруулах ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд ТХБ-ыг тусгасан байна.
 - Бүх түвшний сургалтын байгууллага болон багш нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд ТХБ-ыг түгээн дэлгэрүүлэх, суралцагчдын мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэх, хандлага төлөвшүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, үнэлдэг, урамшуулдаг болно.
 - Суралцахуйн орчинг хувирган өөрчлөхөд байгууллага бүхлээрээ ажиллах арга хандлагын сайн туршлагыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох ажлыг хэрэгжүүлнэ.
 - Суралцагчид ТХБ-ын талаар салбар дундын төсөлд суурилсан суралцахуй, түүнийг дэмжих үйл ажиллагаагаар дамжуулан хувирган өөрчлөх суралцахуй ба багшлахуйн зарчмууд хэрэгжиж эхэлнэ.
 - ТХБ-ыг түгээн дэлгэрүүлэх, суралцагчдын мэдлэг, үр чадвар, хандлага төлөвшилийг дэмжих чиглэлээр хийж байгаа ажлын үр дүн, туршлагаа хуваалцах, харилцан суралцах ТХБ-ын платформ бий болсон байна.
 - Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага бүр тухайн байгууллагадаа ажиллаж байгаа залуусынхаа дуу хоолой, үзэл бодлыг сонсох нээлттэй өдөрлөгийн үйл ажиллагааг улирал тутам зохион байгуулж, шийдвэр, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлдэг болно.

- Иргэдийн ТХБ-ын мэдлэг, ойлголт, оролцоог нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг орон нутгийн түвшинд сургалтын байгууллагыг түшиглэн албан ба албан бус боловсролын хэлбэрээр тасралтгүй зохион байгуулна.
- ТХБ-ыг ухуулан сурталчилах зорилгоор олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн бодлогод ТХ, ТХБ-ын асуудлыг тусгаж, энэ чиглэлийн тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэхэд иргэдийн оролцоо ямар чухал тухай асуудал дэвшүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлэг, хэлэлцүүлэг, ярилцлагыг тасралтгүй бэлтгэж түгээнэ.

3. Засаглал

3.1. Улс орны санаачилгыг боловсруулахын тулд хувь нийлүүлэгчдийг дайчилсан байдал

ТХБ 2030 Монгол Улсын санаачилгыг боловсруулах ажлыг БШУЯ-ны зөвшөөрлөөр тус яамны харьяа Боловсролын хүрээлэн ЮНЕСКО-ийн Үндэсний Комисстой байгуулсан гэрээний хүрээнд зохион байгуулсан. Боловсролын хүрээлэнгийн захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд, бие даасан үндэсний шинжээч-зөвлөх, БШУЯ-ны төлөөлөл багтсан. Ажлын хэсэг нь уг санаачилгыг боловсруулах ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны аргачлал, удирдамжууд боловсруулж батлуулсан. Батлагдсан удирдамж, аргачлалын дагуу ТХБ 2030-ын тэргүүлэх чиглэлүүдтэй холбоотой Монгол Улсын ТХБ-ын өнөөгийн байдлын талаарх мэдээллийг боловсролын болон байгаль орчны салбарын төлөөллөөс цуглуулан боловсруулж, үнэлгээ хийсэн.

Улс орны санаачилгын төслийг боловсруулахдаа Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд, БШУЯ-ны мэргэжилтэн, шинжээчид, холбогдох бусад хүмүүст зориулан хэд хэдэн удаагийн сургалт зохион байгуулж, тэднийг санаачилгын эхний төсөл боловсруулахад татан оролцуулсан. Тухайлбал:

- Боловсролын хүрээлэнгийн хүний хөгжил, дээд болон мэргэжлийн боловсролын, боловсролын хөтөлбөр, сурах бичиг сургалтын орчин, тусгай хэрэгцээт боловсрол, үндэсний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааг тус тус хариуцдаг секторын эрхлэгч болон эрдэм шинжилгээний ажилтнууд
- БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар, Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын мэргэжилтэн, шинжээчид оролцсон.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч байлцсан.

Улс орны санаачилгыг хэрэгжүүлэхэд улсын ба орон нутгийн төсвөөс гадна хөгжлийн түншүүдийн санхүүжилт, дэмжлэгийг дайчилна гэж төлөвлөж байна. Тус санаачилгын хэрэгжилтэд боловсрол, тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцсан үндэсний түвшний байгууллагуудаас гадна орон нутгийн захиргааны байгууллагууд, бүх шатны боловсрол,

сургалтын байгууллагууд, сурган хүмүүжүүлэгчид, суралцагчид, залуусын байгууллага идэвх, санаачилгатай оролцоно гэсэн хүлээлттэй байгаа юм.

3.2. Улс орны санаачилгын засаглал Улсын Их Хурлын тогтоолоор Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо 2020 онд Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдан ажиллаж байна. Мөн Ерөнхий сайдын даргалдаг Тогтвортой хөгжлийн үндэсний хороо ажилладаг. Монгол Улсын БШУЯ, БОАЖЯ, бусад яамд, Үндэсний хөгжлийн газар, Үндэсний статистикийн хороо зэрэг төрийн байгууллага тус бүрийнхээ эрхлэх асуудал, чиг үүргийн хүрээнд ТХЗ-ын хэрэгжилтийг хариуцдаг.

Одоогийн байдлаар ТХБ-ын асуудлыг хариуцдаг тусгайлсан институт байхгүй бөгөөд Улс орны санаачилгыг боловсруулах болон ШХА-с хэрэгжүүлж буй “ТХБ-II” төслийн хүрээнд “ТХБ-ын төлөвлөлт, хэрэгжилт, сүлжээ, хяналт шинжилгээ, тайлагнал харилцаа холбооны ерөнхий зохицуулалтыг хариуцсан улс орны түвшинд ажиллах институтыг ажиллуулах” санаачилгыг хэлэлцэж байна. Хэдий тийм ч БШУЯ эрхлэх асуудал, чиг үүргийнхээ хүрээнд ТХБ-ыг түгээн дэлгэрүүлэх ажлыг манлайлан хэрэгжүүлэх бөгөөд тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, хөгжлийн түншүүдтэй нягт хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа үялдуулах хэрэгтэй болно.

Энэ хэрэгцээ шаардлагын дагуу УИХ-д өргөн барьсан Боловсролын тухай ерөнхий хуулийн Боловсролын байгууллага, түүний ангилал гэсэн гуравдугаар бүлэгт “Насан туршийн суралцахуй” гэсэн шинэ зүйлийг нэмж, түүний 20.2 дугаар заалтад “Насан туршийн суралцахуйн бодлого, үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтыг хариуцах салбар дундын зөвлөл байна” түүнчлэн 20.3 дугаар заалтад “Энэ хуулийн 20.2-т заасан Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заажээ. Хэрвээ хуулийн төслийн энэ заалт батлагдвал ТХЗ 4 ба ТХБ-2030-ын сектор дамнасан нэгдсэн бодлого, зохицуулалтыг хариуцсан шинэ бүтэц бий болж, түүний чиг үүрэг тодорхой болох боломжтой юм. Аль ч тохиолдолд бүх түвшний, бүх төрлийн байгууллагуудын төлөөлөл бүхий салбар дундын удирдлага, зохион байгуулалтын зохистой механизмуудыг бүтээж ажиллуулах шаардлагатай бөгөөд тэдгээрийн гол зохицуулагчид нь БШУЯ, тус яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар болон бусад газар хэлтсүүд байх болно.

3.3. Үйлийн тэргүүлэх чиглэл бүрээр холбогдох хоёр гол байгууллагыг жагсааж, дэлгэрэнгүй жагсаалтаас байгууллагын төрлийг сонголоо. Үйлийн тэргүүлэх чиглэлд хамрагдсан бусад гол байгууллагуудыг “Бусад” гэсэн хэсэгт жагсаалаа. Энд боловсрол болон тогтвортой хөгжлийн секторуудын аль алиных нь хувь нийлүүлэгчдийг оролцуулахыг хичээсэн болно.

Үйлийн тэргүүлэх чиглэлүүд	Нэр	Байгууллагын төрөл
ТҮЧ1: Бодлого	Засгийн газар	Governmental Institution
	БШУЯ	Governmental Institution
	Бусад: Боловсролын хүрээлэн	Research Institute
ТҮЧ2: Сургалтын орчин	БШУЯ	Governmental Institution
	ХХААХҮЯ	Governmental Institution
	Бусад: БОАЖЯ	
ТҮЧ3: Сурган хүмүүжүүлэгчид	Боловсролын ерөнхий газар	Governmental Institution
	МУБИС	Higher Education Institution
	Бусад: Мэргэжлийн холбоод, багш бэлтгэдэг их дээд сургуулиуд, Иргэний нийгмийн байгууллагууд	
ТҮЧ4: Залуучууд	НХХЯ	Governmental Institution
	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Governmental Institution
	Бусад: Хэвлэл мэдээллийн байгууллага, Залуучуудын байгууллага	
ТҮЧ5: Орон нутгийн үйл	Аймгийн ИТХ	Municipal Government
	Аймгийн Засаг дарга, тамгын газар	Municipal Government
	Бусад: Орон нутгийн Боловсролын газрууд, Иргэний нийгмийн байгууллагууд	

4. Улс орны санаачилгын үйл ажиллагаа

Энэ хэсгийн “Хэрэгжиж буй үйл ажиллагаа”-нд өмнө танилцуулсан Монгол улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөөний хүрээнд, ТХБ-ын чиглэлээр хийж буй гол үйл ажиллагааг багтаалаа. Харин “Төлөвлөсөн үйл ажиллагаа” хэсэгт хийхээр төлөвлөсөн, хийх хэрэгтэй гэж үзсэн гол үйл ажиллагааг жагсаан бичлээ.

4.1. Бие даасан байгууллагуудын онцлог үйл ажиллагаа

Хэрэгжиж буй үйл ажиллагаа	Хариуцаж буй байгууллага(ууд)	Тайлбар	ТХБ гол чиглэл
“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулсан бөгөөд Хөгжлийн бодлогын эрхэм 9 зорилгын нэгд “Ногоон хөгжлийг эрхэмлэн байгаль орчны тогтвортой байдлыг хангана” гэсэн байна.	МУЗГ	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Монгол Улс 2050 он гэхэд байгаль, хэл, хил, соёлоо тогтвортой хадгалсан, нийгмийн болон эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэгч орон болно” гэж тодорхойлсон бөгөөд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтуудад ТХБ-ын агуулгыг тусгасан байна. Тухайлбал, Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Ногоон хөгжил бүлгүүдийн хэд хэдэн зорилтод тусган хэрэгжүүлэхээр заажээ.	Policy
Боловсролын багц хуулийг шинэчлэн найруулж, УИХ-д өргөн барьсан ба хуулийн зарим заалтад боловсролын тогтолцооны тухай ойлголтыг НТС-н үзэл баримтлалын үүднээс нэрлэн өргөтгөж, уг тогтолцоог албан ба албан бус, амьдралын орчноос суралцахүйн нэгдэл хэмээн тодорхойлж, тэдгээртэй холбогдон үүсэх шинэ харилцаануудыг хуульчилсан.	БШУЯ	Боловсролын ерөнхий хуулийн төсөлд ТХЗ 4-ийн хүрээнд боловсролын тогтолцоо, зарчим, эрдэм шинжилгээний байгууллага, аймгийн боловсролын газар, дүүргийн хэлтсүүд, аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ, бүх шатны Засаг дарга, боловсролын харилцаанд оролцогч бүх хуулийн этгээдийн эрх үүрэг, цахим мэдээллийн сан, аюулгүй байдлын удирдлагад НТС-н хууль эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн байна. ТХБ-ын үзэл санаа, агуулгыг бүх шатны боловсролын хөтөлбөр, арга зүйд заавал тусгаж, өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлэхээр хуульчилж өгсөн байна. Тухайлбал, 14.4.2. хувь хүн, гэр бүлийн төлөвшил, амьдрах ухаан, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл; 14.4.6. байгаль хамгаалал, экологи, ногоон хөгжил г.м https://lawforum.parliament.mn/draft/75/	Policy

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030) батлагдсан.	БШУЯ	Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа иргэн бүрд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг олгох, боловсролын бодлогын босоо болон хөндлөн уялдааг хангах, ухаалаг, дижитал технологийг бүх түвшний боловсрол, сургалтад ашиглах, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн болон үйл ажиллагаанд ногоон хөгжлийг дэмжих зэрэг зарчмуудыг баримталсан байна.	Policy
“Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг (2016-2030) боловсруулан хэрэгжүүлж байна.	МУЗГ	Олон улсын Байгаль Орчны Сангийн “Эко сургууль” хөтөлбөрт 2018 оноос нэгдэж, үндэсний оператораар “байгаль орчны мэдээлэл, сургалтын төв (БОМСТ)” ТББ байгууллага ажиллаж байна. 2021 оны 12 сарын байдлаар нийт цэцэрлэгийн 8 хувь, ерөнхий боловсролын нийт сургуулийн 40 хувь, МСҮТ-ийн 6 хувь нь тус тус хамрагдсан байна. Эко сургууль хөтөлбөр нь хүрэл, мөнгө, алтан Гэрэгийн болзол хангасан байхаар 3 шаттайгаар хэрэгждэг. Өнөөдрийн байдлаар уг хөтөлбөрт хамрагдсан нийт сургуулийн 15 хувь нь олон улсын “Ногоон туг” болзолыг хангаж, олон улсад туршлагаа хуваалцаж эхэлсэн байна. Эко сургуулиар дамжуулан уламжлалт ёс заншил, байгаль хамгаалах орчин үеийн арга технологи, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, зөв хандлагыг түгээх зорилготой. Энэ ажлын үр дүнд байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хүүхэд, залууст төлөвшүүлэх хөдөлгөөн идэвхижиж, өргөн цар хүрээг хамарч эхэлсэн.	Learning environment

2018 оноос “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль” батлан мөрдөгдөж байна. Энэхүү хуулийн Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх чиглэлүүдэд ТХЗ-ын үзэл санааг тусгасан байдаг. Үндэсний болон орон нутгийн хэмжээнд Залуучуудын хөгжилд чиглэсэн олон талт ажиллагааг дэмжин ажиллах Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, “Залуучуудын хөгжлийн газар” байгуулагдан ажиллаж байна.	ХНХЯ	ГБХЗХГ нь Хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжил оролцоог дэмжих, эрсдэл хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж байгаа бол Залуучуудын хөгжлийн газар нь тэдний хөгжилд чиглэсэн олон талт үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, ТХБ-ын үзэл санааг хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэх төрийн бүтэц бий болж байгаа юм.	Youth
ЕБС-д 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш нарт сонголтоор сургалтын 12 цагаар ТХБ-ын агуулгыг онлайн болон бие даан судалдаг. Түүнээс гадна бүх мэргэжлийн багш нар ТХЗ-ын төлөөх боловсролын суралцахуйн зорилт, судлах сэдэв, хэрэгжүүлэх арга зүйг зөвлөсөн гарын авлагыг ашиглах боломжоор хангагдсан.	БМДИ	“ТХЗ-ын төлөөх боловсролыг суралцахуйд интеграцчилах арга зүй” гарын авлагыг 2018 онд БМДИ-ээс “ТХБ1” төслийн хүрээнд боловсруулж, нийтийн хүртээл болгосон. Түүний хоёрдахь хэвлэлийг 2021 онд БХ-ээс бэлтгэн дахин хэвлэхийн зэрэгцээ багш нарт онлайнаар ашиглах боломжийг бүрдүүлсэн. Эдгээр гарын авлага нь бага, суурь, бүрэн дунд гэсэн 3 түвшинд багцлагдан ЕБС-ийн бүх ангийн бүх хичээлийн нэгж хичээлийн төлөвлөлтийн жишээнүүдийг багтаасан. Энэ нь ЕБС-ын багш нарт ТХБ-ыг цэгцтэйгээр ойлгуулах, хичээлдээ турших, шинэ хичээлүүд бүтээхэд удирдамж болж, тэднийг чадавхижуулах зориулалттай.	Capacity building of educators

ТХЗ 4-ийн Зорилт 4.2-ийн хэрэгжилтийг хангах үүднээс хот суурин газраас алслагдмал амьдарч буй малчин айл, нийгмийн эмзэг бүлэг болон бусад бүлэгт хамаарах айл, өрхийн хүүхдүүдийг ээлжийн, явуулын, нүүдлийн бүлгийн сургалтын хэлбэрээр СӨБ эзэмшүүлэх дүйцсэн хөтөлбөрүүдийг боловсруулж, хувилбарт сургалтуудад хамруулж байна.	БШУЯ	Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, түүний алсын хараа, зорилтууд, Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийн салбар дамнасан агуулга, ялангуяа ТХЗ 4-тэй нийцүүлэн насан туршдаа суралцахуйн цогц үзэл хандлагаар боловсруулагдсан Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ тайланд дурьдсанаар 2019 оны байдлаар “алслагдсан орон нутгийн малчин өрхийн СӨБ-ын насны хүүхдүүдийн 69% нь нүүдлийн бүлэг болох гэр цэцэрлэгт, 12% нь явуулын багшийн сургалтад хамрагдаж байна.	Learning environment
Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) ажиллаж байна.	Орон нутаг	ОНХС-ын тодорхой хувийг аймаг, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдийн идэвх оролцоо, санаачилга, манлайллыг урамшуулахад зарцуулах, хөхиүлэн дэмжих замаар аймаг, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд хэрэглээний хэмнэлттэй зөв дадлыг бий болгох ажлын эхлэл тавигдсан байна.	Local community
Төлөвлөсөн үйл ажиллагаа	Хариуцаж буй байгууллага(үүд)	Тайлбар	ТХБ гол чиглэл
Цаг уурын боловсрол, зохистой хэрэглээний үр чадварыг хөгжүүлэх агуулга, үйл ажиллагаа (activity)-г оролцуулан ТХБ-ын үзэл санаа, агуулгыг бүх түвшний албан боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах, хэрэгжүүлэх	БШУЯ	2024 онд ЕБ-ын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах ажил хийгдэнэ. Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх арга зүй, аргачлал гарах хэрэгтэй.	Learning environment

Боловсролын бүх шатны байгууллагын болон багш, сурган хүмүүжүүлэгчид, сурагчдын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт ТХБ-ын шалгуурыг тусгах, уг шалгуурын хүрээнд цуглуулсан мэдээллээр боловсролын салбарын болон үндэсний мэдээллийн сан бий болгох	БШУЯ	Бүх түвшний сургалтын байгууллага болон багш нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд тогтвортой хөгжлийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх, суралцагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, үнэлдэг, урамшуулдаг болно.	Policy
ТХБ-II төслийн хүрээнд СБААХ-ын талаар бий болсон мэдлэг, сайн туршлагыг сонгосон аймаг, байгууллагын хүрээнд түгээн дэлгэрүүлэх	БШУЯ ШХА	ТХБ-ын төлөөх ББААХ-ыг байгууллагын менежментэд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх зорилготой.	Policy
ББААХ-ыг ТХБ-ын үйл хэрэгт интерацчилах үндэсний загварыг бий болгох, сурталчилах	Боловсролын хүрээлэн ШХА	Төрийн байгууллагын хэмжээнд ББААХ-ын үзэл санаа, ойлголт мэдлэгийг түгээх сурталчилах	Research Advocacy
Багш бэлтгэх болон багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсролын мэдлэг, ойлголтыг тусгах	Багш бэлтгэх ИДС-ууд	Багш бэлтгэх болон багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн бүх төрлийн сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсролыг тусгана.	Learning environment
Багш нарт тогтвортой хөгжлийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх, суралцагчдын мэдлэг, үр чадвар, хандлага төлөвшилийг дэмжих чиглэлээр хийж байгаа ажлын үр дүн, туршлагаа хуваалцах, харилцан суралцах платформыг бий болгох	Боловсролын ерөнхий газар	Багш нар туршлагаа хуваалцаж, харилцан суралцах боломж бүрдсэнээр суралцагчдын тогтвортой хөгжлийн боловсролын мэдлэг, үр чадвар, хандлага төлөвшилд илүү ахиц гарна.	Capacity building of educators
Байгаль орчноо хамгаалах уламжлал ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх чиглэлээр мэдээ, мэдээллээр нутгийн иргэдийг тэгш хүртээмжтэйгээр хангах мэдээллийн хэрэгсэл тогтмол ажиллуулах	ХМХ	Нүүдлийн соёлын байгальтай харилцах, дээдлэх үнэт зүйлийг хадгалан түгээн дэлгэрүүлэх нь ТХБ-д хувь нэмэр оруулна.	Advocacy

ТХБ-ыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн бодлогод ТХБ-ын төлөөх асуудал дэвшүүлсэн олон нийтийн цаг хэлэлцүүлэг, ярилцлагын нэвтрүүлгийн төрөл бий болгож үйл ажиллагааг нь тогтмолжуулах.	МҮОНРТ	МҮОНРТ нь бие даасан хуультай, олон нийтийн статустай байгууллага юм.	Advocacy
Залууст тогтвортой хөгжлийн сорилтуудтай холбоотой мэдээ, мэдээллийг түгээх, хамтын арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулахыг дэмжих платформыг бий болгох	ГБХЗХГ, залуучуудын төрийн бүс байгууллагууд	Залуусын тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр, оролцоо нэмэгдэнэ.	Youth
Тухайн байгууллагад ажиллаж байгаа залуусынхаа дуу хоолой, үзэл бодлыг сонсох нээлттэй өдөрлөгийн үйл ажиллагааг улирал тутам зохион байгуулах	Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага	Тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа залуусын дуу хоолойг сонсох, тэдний үзэл бодол, байр суурийг тусгадаг болно.	Youth
ТХЗ бүрээр иргэдийн ТХБ-ын судалгааг үндэсний болон олон улсын эрдэмтэд хамтран хийх	Боловсролын хүрээлэн		Research

5.2. Хамтын болон зохицуулалттай нэгдсэн үйл ажиллагаа

Хэрэгжиж буй үйл ажиллагаа	Хариуцаж буй байгууллага(ууд)	Тайлбар	ТХБ гол чиглэл
Дунд хугацааны буюу 10 жилд хэрэгжих Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулж байна.	МУЗГ БШУЯ Сангийн яам ЭМЯ	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулж байгаа бөгөөд Зорилт 2.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ гэж заасан байна.	Policy

ЕБС-ийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө /2021-2023/-г боловсруулан хэрэгжүүлж байна.	БШУЯ, БХ, БМДИ, БҮТ ба бусад мэргэжлийн байгууллагууд, СӨБ, БДБ-ын байгууллагууд	Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, нийгэм, сэтгэл зүйн хэвийн байдлыг хангах, тулгарсан асуудлыг шийдвэрлэхийн тулд энэхүү төлөвлөгөөг боловсруулсан. Мөн талуудын оролцоо, тэдгээрийн үйл ажиллагааны үйлдаа холбоог чухалчилсан.	Policy
Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2016 онд баталсан. Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого, ЕБС-ийн сургалтын орчны аюулгүй байдалд тавих ерөнхий шаардлага боловсруулан мөрдөж байна. Хот, суурин газарт ЕБС-д “School policy” ажиллаж байна.	БШУЯ ЗЦГ ЕБС	Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогын зорилго, ЕБС-ийн сургалтын орчны аюулгүй байдалд тавих ерөнхий шаардлагын дагуу хүүхдийн эрүүл, аюулгүй материаллаг бүс үйлчилгээний орчин бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна.	Learning environment
ТХБ-II төсөл 6 аймаг, 30 сургуульд хэрэгжиж байна. Төслийн хүрээнд: - СБААХ-ыг туршин нэвтрүүлж байна. - 30 сургуулийг сэтгэл зүйчээр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлж эхлээд байна.	БШУЯ БХ ШХА ТХБ II төслийн хамтрагч байгууллагууд	БОМСТ (Байгаль орчин мэдээлэл сургалтын төв)-ын СБААХ (сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага) багц гарын авлага боловсруулан түгээн дэлгэрүүлж эхлээд байна. Зорилтот зарим сургуулиудад “Дотоод орчин ба эсгий самбарын аян, Хөгжлийн төлөө түншлэл, Хамтын хөрөнгө оруулалт” Нарлаг сургууль, ухаалаг хэрэглээ” гэсэн жижиг төсөл хэрэгжүүлж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн “Сэтгэл зүйч ажиллуулах бэлтгэх ажлыг хангах тухай” А/266 дугаар тушаалаар ерөнхий боловсролын лаборатори сургууль, олон улсын хөтөлбөртэй сургуулиудад сэтгэл зүйч ажиллуулах, сэтгэл зүйчийг мэргэшүүлэх сургалтад хамруулахаар шийдвэрлэн хэрэгжүүлж байна.	Learning environment

МУ-ын Засгийн Газрын Үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөрийн 2.3.9 дэх зорилтын хүрээнд цэцэрлэг, ЕБС-иудын гаднах “модон жорлон”-г өөрчилж, ариун цэврийн нөхцөлийг сайжруулж байна.	БШУЯ БОАЖЯ	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтыг дэвшүүллээ.	Learning environment
“Үдийн цай”-г “Үдийн хоол” болгож, шүүлтүүртэй цэвэр усаар хангаж байгаа.	БШУЯ ЕБС ЭМЯ	Цэцэрлэг, дотуур байр, ЕБС-ийн хүүхдийн хоолны зардлыг инфляци, үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн.	Learning environment
“Түгээмэл загвар”-ын сургуулиудыг барьж байна.	БШУЯ Японы ЗГ-ын буцалтгүй тусламж БХТЯ	Алсын хараа 2050-ын 2.1.12-д боловсролын тогтолцооны гадна байгаа, завсардаж, хоцорч байгаа суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна гэж заасны дагуу тогтвортой байдлын төлөө ажиллаж буй орон нутгийн удирдлагууд, сургууль, гэр бүлүүд хамтран ажиллах боломж бүрдэж байна.	Learning environment
Албан ба албан бүс боловсролын сургалтад хэрэглэх цахим сургалтын суурь платформыг хөгжүүлэх (сурах бичгийг цахим хувилбар руу хөрвүүлэх, теле хичээл, интерактив, цахим контент, радио болон аудио хичээл...) ажлыг хийн түгээж эхлээд байна.	БШУЯ БХ, БМТТ, БМДИ, НТБҮТ	Аймаг, орон нутгийн, алслагдмал баг, хороонд амьдарч байгаа хүүхдүүд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сургалтын материалуудыг үзэж судлах боломжоор хангагдаж байна.	Learning environment
“Нэг тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөн өрнөж, ойн санг нэмэгдүүлэх, мод тарих хөдөлгөөнийг эрчимжүүлэх, урамшуулах, хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж байна.	Бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд	“Нэг тэрбум мод” үндэсний санаачилгын хүрээнд цаг уурын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн боловсролын хөтөлбөрийг тогтвортой байдлын төлөө ажиллаж буй төрийн болон ТББ-ын төлөөлөлтэй хамтран боловсруулж, хэрэгжүүлэх ажил хийгдэж байна.	Partnership

НТБ-ын төв нь харьяа орон нутгийн хүн амын боловсролын хэрэгцээг хангах зорилгоор сургалт, нөлөөллийн ажил хийж байна.		Хот хөдөөгийн НТБ-ын төв нь бичиг, үсгийн боловсролын, дүйцсэн хөтөлбөрийн, насан түршийн боловсролын 5 чиглэлийн агуулгын хүрээнд дэх сургалтаар дамжуулан ТХБ-ын суралцагчдад эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хүүхэд бүрд хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, сургалтын таатай, тэгш хүртээмжтэй орчныг бүрдүүлэх талаарх мэдлэг, ойлголтыг хүргэж байна.	Capacity building of educators
ТХБ-II төслийн хүрээнд “ТХ, ТХЗ, ТХБ ба Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, санаачилга” үндэсний цахим зөвлөгөөнийг 10 гаруй байгууллага хамтран тэргүүн түршлага бий болгох зорилгоор зохион байгуулсан.	БШУЯ БХ ШХА ТХБ II төслийн хамтрагч байгууллагууд	Үндэсний хэмжээний энэ арга хэмжээ нь байгаль орчин, боловсрол, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн үндэсний болон орон нутгийн бүх түвшний төрийн захиргааны болон мэргэжил, арга зүйн институт, ерөнхий боловсролын сургуулийн төлөөллийг хамруулсан.	Partnership
Орон нутгийн иргэд, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах сонин хэвлэл, радио FM, телевиз, цахим хэвлэлээр дамжуулан нутгийн захиргааны бүх шатны байгууллагын хэмжээнд ТХБ-ын чиглэлээр хэрэгжиж байгаа ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд олон нийтэд мэдээлэх, таниулах үйл ажиллагааг хийж байна.	Орон нутгийн засаг захиргаа	Орон нутгийн радио FM, TV-ээр дамжуулан ТХБ дах үндэсний эв нэгдэл, хүн бүрийн хэрэгцээнд суурилсан тэгш оролцоо (inclusion)-г хангах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлаар мэдээлэл, хэлэлцүүлэг, түүнчлэн үйл явцын талаар түршлага солилцох тогтмол нэвтрүүлэг явуулах боломж бүрдэж байна. Өөрөөр хэлбэл, мэдээ мэдээллийг орон нутгийн иргэдэд тогтмол хүргэх нэгдсэн сүлжээ бий болсон байна.	Local community
Төлөвлөсөн үйл ажиллагаа	Хариуцаж буй байгууллага(ууд)	Тайлбар	ТХБ гол чиглэл
Тогтвортой хөгжлийн боловсролыг “Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “Байгаль орчны зорилтот хөтөлбөр” зэрэгт тусгах	БШУЯ, ЗГХЭГ, БОАЖЯ	Монгол Улсын Засгийн газраас боловсруулж буй 2020-2030 онд хэрэгжүүлэх хөгжлийн 7 зорилтот хөтөлбөрийн хэсэг болох “Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “Байгаль орчны зорилтот хөтөлбөр”-ийн үзэл баримтлал, зорилго, зорилт, бодлогын хувилбарт ТХБ-ыг түгээн дэлгэрүүлэх ажлыг төлөвлөн тусгана.	Policy

Насан туршдаа суралцахуйн бодлого, стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх	БШУЯ, БОАЖЯ, ЭМЯ, ХНХЯ болон бусад яамд	Насан туршдаа суралцахуй нь салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагаа шаардсан бүх хүний амьдралын туршид суралцах мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил байдаг. Тиймээс тогтвортой хөгжлийн мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлсэн тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих насан туршдаа суралцахуйн тогтолцоог бий болгож, хөгжүүлэх бодлого, стратегийг боловсруулж, хэрэгжүүлнэ.	Policy
Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дэмжлэг болох ургамлын гаралтай хүнс, бүтээгдэхүүн үйлдвэрлэх мэдлэг ойлголт, ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх (веган хөтөлбөр)	ХХААЯ, ЭМЯ, БШУЯ	Энэ чиглэлээр үндэсний хэмжээнд болон олон улсын түвшинд цуглуулсан туршлага, сургамжийг үндэслэн хийх боломжтой юм.	Policy
“Нэг тэрбум мод” үндэсний санаачилгатай холбон цаг уурын боловсрол, зохистой хэрэглээний ур чадварыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах	Ерөнхийлөгчийн тамгын газар, ЗГХЭГ, БШУЯ МҮОНРТ	Энэхүү үндэсний санаачилгын хүрээнд нэгж байгууллагаас эхлээд аймаг бүр үүрэг амлалт авч байгаа бөгөөд үүнтэй уялдуулан хэрэгжүүлэх боломжтой.	Partnership
Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, барилгын материалыг ногоон болгох чиглэлээр барилгын салбарын ажиллагсдыг сургалт, үйл ажиллагаанд хамруулах	БШУЯ, БХБЯ, БОАЖЯ	Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг шинээр барьж буй болон засвар шинэтгэл хийж буй ажиллагсад тухайн салбарын онцлог, түүнийг ногоон болгох хэрэгцээ, арга зам, инновацид суралцах шаардлагатай.	Learning environment
Боловсролын байгууллагад ногоон худалдан авалтыг нэвтрүүлэх үзэсгэлэн яармаг зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах, сурталчилах	БШУЯ, ... ХМХ	Боловсролын байгууллагаас хийж буй бүхий л худалдан авалтыг аль болох ногоон болгохын тулд худалдан авалтыг хийдэг, зохион байгуулдаг ажиллагсад энэ талын мэдлэг, чадвартай байх хэрэгтэй.	Advocacy

Бүх түвшний сургалтын байгууллагууд орон нутгийн захиргаа, гэр бүл, иргэний нийгмийн байгууллага болон хувийн хэвшилтэй хамтран тогтвортой хөгжилд чиглэсэн салбарын дундын төсөлд суурилсан суралцахуй, үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх	БГ, СБ-ууд, орон нутгийн захиргаа, ИНБ, хувийн хэвшил, иргэд	Суралцагчид тогтвортой хөгжлийн боловсролын тухай зөвхөн сургалтын байгууллагын орчинд суралцах бус салбарын дундын төсөлд суурилсан суралцахуй, үйл ажиллагаагаар дамжуулан нутаг, орныхоо тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой болно.	Learning environment
Орон нутаг дахь сонирхлын бүлгүүдийн хүрээнд ТХБ-ын дэмжлэг үйл ажиллагааг зохион байгуулах	Орон нутгийн ИНБ, бүлэг	Орон нутагт хүүхдийн, залуучуудын, ахмадын, эмэгтэйчүүдийн, бөхчүүдийн, уяачдын, тариаланчдын, малчдын, бизнес эрхлэгчдийн гэх мэт сонирхлын бүлгүүд байдаг.	Local community
Аймаг, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөртөө тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл, ногоон худалдан авалтыг дэмжих, байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, хэмнэлттэй хэрэглээг бий болгох чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэхдээ олон нийтийн оролцоог хангах	Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчид	Орон нутгийн хөгжлийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон орон нутагт хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд хэрэгжих боломжтой.	Local community

5.3. Улс орны санаачилгын хүрээнд хийгдэх хяналт-шинжилгээ

Үйлийн тэргүүлэх чиглэл	ТХБ-2030 ахиц дэвшлийг хянаж шинжлэх гол индикаторууд	Тэдгээрийг хэрхэн хянаж шинжлэх талаар (суурь түвшний мэдээлэл, эх сурвалж, арга хэрэгсэл)	Санал (хяналт-шинжилгээнд тулгарч буй сорилтууд, боломжууд)
ҮТЧ 1: Бодлого	ТХБ-ыг дэмжин урагшлуулахад үйлчилдэг хууль эрх зүйн зохицуулалт ба бодлогын хүрсэн түвшин (extent)	Тогтвортой хөгжлийн боловсрол тусгалаа олсон хөгжлийн баримт бичгийн тоо Насан туршдаа суралцахуйн бодлого, стратеги батлагдсан эсэх	Бодлогын баримт бичгүүдийн боловсруулах, батлагдах үйл явц удаашрах эрсдэлтэй.
ҮТЧ 2: Сургалтын орчин	ТХБ болон Байгууллага бүхлээрээ ажиллах хандлагыг сурталчилан дэмжихэд суралцахуйн орчны хүрсэн түвшин (extent)	Байгаль орчинд ээлтэй орчин бүрдүүлсэн эко сургалтын байгууллагын сургалтын нийт байгууллагад эзлэх хувь СБААХ-ыг нэвтрүүлсэн сургалтын байгууллагын нийт байгууллагад эзлэх хувь	Сургалтын орчинг хувирган өөрчлөхөд шаардагдах төсөв, санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй.

ҮТЧ 3: Сурган хүмүүжүүлэгчид	ТХБ-ыг түгээн дэлгэрүүлэхээр бэлтгэгдсэн сурган хүмүүжүүлэгчдийн чадавхын хүрсэн түвшин (extent)	Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтад хамрагдсан багш нарын нийт багш нарт эзлэх хувь Багш нарын тогтвортой хөгжлийн боловсролын мэдлэг, ойлголтод гарсан ахиц	Багш нарын тогтвортой хөгжлийн боловсролын мэдлэг, ойлголтын суурь түвшин болон ахицад гарсан өөрчлөлтийг тодорхойлох судалгаа хийх хэрэгтэй.
ҮТЧ 4: Залуучууд	ТХБ-ын төлөөх үйл хэрэгт хамрагдахад залуучуудын оролцооны хүрсэн түвшин (extent)	ТХБ-ын чиглэлээр ажилладаг залуучуудын байгууллагын үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын тоо Залуусын хөгжлийн индекс	Залуусын хөгжлийн индекс бүхий олон улсын тайлан хэвлэгддэг.
ҮТЧ 5: Орон нутгийн үйлүүд	ТХБ-ыг дэмжин урагшлуулах үйл хэрэгт орон нутгийн олон нийтийн хүрсэн түвшин (extent)	Орон нутгийн түвшинд зохион байгуулагдсан арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо Тогтвортой хөгжлийн боловсролд зарцуулсан орон нутгийн төсвийн зарлагын хувь	Орон нутгийн төсвийн орлого хязгаарлагдмал байдгаас тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр зарцуулах санхүүжилт хязгаарлагдмал байж болно.

5. Түншлэл, амжилтыг тэмдэглэх, ил тод байдал

5.1. Улс орны санаачилгын хүрээнд янз бүрийн хувь нийлүүлэгчид хоорондоо харилцаж, мэдээлэл солилцон, түншлэл ба хамтын ажиллагааг бий болгож буй байдал

“Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл” сэдэвт үндэсний нэгдсэн арга хэмжээг 2021 оны 3 сарын 14-нөөс 4 сарын 22 хүртлэх хугацаанд цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан байна. Энэхүү арга хэмжээг зохион байгуулахад Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, төслийн түшиц байгууллага-Боловсролын Хүрээлэн, төслийг орон нутагт хэрэгжүүлэгч Байгаль Орчны Мэдээлэл Сургалтын Төвийн нэгдсэн удирдлага, манлайлал доор Техникийн Зөвлөн Зохицуулах Баг (ТЗЗҮБ)-ийн гишүүн байгууллагууд болон ЮНЕСКО-ийн Монголын үндэсний зөвлөл хамтран ажиллажээ. Нэгдсэн арга хэмжээнд Zoom, facebook, youtube зэрэг онлайн орчинд нийт 108 766 хүн шууд болон шууд бусаар оролцсон байна.

Уг арга хэмжээ нь засгийн газар болон байгаль орчин, боловсрол, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн үндэсний, орон нутгийн нэгж байгууллагын түвшний төлөөллийг хамруулж, ТХБ-ын чиглэлээр хийж буй ажил, түүний үр дүнгийн талаар мэдээлэл, түршлагаа солилцсон байна. Арга хэмжээний хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

1. “Дэлхийн том хичээл-Тогтвортой хөгжлийн боловсрол” хэлэлцүүлэг (багш нар болон бусад оролцогчдын хүрээнд);

2. “Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэл-Орон нутгийн манлайлал” олон нийтийн форум
3. “Хүүхдийн эрх-Эрүүл, аюулгүй, ногоон сургалтын орчин” салбар хоорондын хэлэлцүүлэг (хяналтын болон боловсролын байгууллагуудын төлөөллийн хүрээнд);
4. “Бүх түвшний тогтвортой хөгжлийн боловсролд тулгарч буй онол, практикийн асуудлууд” олон улсын эрдэм шинжилгээний хүрал;
5. “Өсвөр үеийнхний дуу хоолой-Байгаль орчны залуу сурвалжлагч” хүүхэд залуучуудын форум;

5.2. Улс орны санаачилгын ололт амжилт

“Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл” арга хэмжээг цаашид үндэсний хэмжээний, тогтвортой үйл ажиллагаа болгох боломжтой. Ингэхдээ хамтрагч байгууллагууд жил бүрийн арга хэмжээг ээлжлэн зохион байгуулах, аль байгууллага хариуцан зохион байгуулахаа тухайн жилийнхээ үйл ажиллагааны төгсгөлд зарладаг байж болно.

With support from



ISBN 9919-9714-6-4



9 789919 971465